

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

ХҮНИЙ НӨӨЦИЙН НӨХӨН ХАНГАЛТЫН ТАЛААР:

Гаалийн байгууллагын сул орон тоог нөхөн хангахаар ГЕГ-ын Салбар зөвлөлөөс тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn гаалийн байгууллагын www.ecustoms.gov.mn цахим хуудсаар олон нийтэд нээлттэй зарлаж энэ оны 01 дүгээр сард төрийн бусад байгууллагаас шилжих зараар нөхөгдөөгүй 86 албан тушаалд хамаарах 152 сул орон тоо, мөн 04 дүгээр сард 77 албан тушаалд хамаарах 139 сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, ГЕГ-ын дэргэдэх салбар зөвлөл шалгалтыг зохион байгууллаа.

Дээрх 2 удаагийн шалгалтын цахим бүртгэлээр 318 иргэн хүсэлт ирүүлсэн материалыг хянан үзэж, шаардлага хангасан 167 иргэнийг бүртгэж шалгалтад хамрууллаа.

Тусгай шалгалтад тэнцсэн нийт 101 иргэнийг тухайн албан тушаалд нь томилуулахаар салбар зөвлөлөөс нэр дэвшүүлснээр, зарлагдсан 291 ажлын байрны 101 буюу 34,7 хувийг нөхсөн.

Салбар зөвлөлийн тогтоолоор 101 иргэнийг томилуулахаар нэр дэвшүүлснээс энэ оны 1 дүгээр сард 59 томилсон /үүнээс өөрийн хүсэлтээр татгалзсан 7, эрүүл мэнд тэнцээгүй учир томилогдоогүй 9/ 7 дугаар сард чиглүүлэх сургалт төгсөж томилогдох 32/ нийт 91 иргэнийг харьяа газар хороонд томилж шийдвэрлэхээр байна. Эндээс харахад:

-Төрийн албаны тухай хууль болон холбогдох журамд заасан шилжих зарын дагуу төрийн бусад байгууллагаас шилжүүлэн авсан 14 төрийн жинхэнэ албан хаагчид гаалийн улсын байцаагчийг эрх олгож, харьяа гаалийн газар, хороодод томилсон байна

- Гаалийн байгууллагын захиалгаар гадаад улсын их, дээд сургуульд сурч төгсөж ирсэн 1 иргэнийг Сургалтын төвд багш гаалийн улсын байцаагчаар томилсон.

- Нийт сул орон тооны нөхөн хангалтыг задалж үзвэл Улаанбаатар хотод 14, хөдөө орон нутагт 44 иргэнийг томилж / анх удаа томилогдож буй 18 иргэнийг туршилтын хугацаагаар томилон ажиллуулж/, 32 иргэнийг гаалийн хэргийн мэдлэг олгох богино хугацааны чиглүүлэх сургалтад хамруулж байна.

Дараагийн сул орон тоог нөхөх шаардлагатай 76 албан тушаалын 146 сул орон тоог зарлаж бүртгэлийг явуулж, шалгалт энэ оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.

Гурав. АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

Гаалийн байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг авч шийдвэрлүүлэв.Үүнд:

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэхээр ГЕГ, дэргэдэх байгууллага, харьяа газар хороодын дарга нийт 367 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоох жагсаалтыг гарган СХОГ-т хүргүүлж,

Засгийн газрын 1997 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох, гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу ГЕГ, дэргэдэх байгууллагын 284 албан хаагчийн нэмэгдэл олгох жагсаалтыг СХОГ-т хүргүүлэв.

Мөн “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.2-т заасны дагуу харьяа гаалийн газар, хороодод журамд заасан шаардлага, шалгуур хангасан албан хаагчдад зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгуулах судалгаа танилцуулгын санал бэлтгэлээ.

"Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын дагуу 2024 онд 13 албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарах хүсэлтийн дагуу 484.1 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгох шийдвэрийг гаргуулав.

Ар гэрт гачигдал тохиолдсон 43 албан хаагчид 28,3 сая төгрөгийн буцалтгүй тусламж, нас барсан 4 албан хаагчийн ар гэрт 50,9 сая төгрөгийн нэг удаагийн тусламж олгож,

Гаалийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч гэр бүлийн гишүүдийн судалгаа гаргаж ажиллаж байна. Тайлант хугацаанд 21 албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 28 албан хаагч тус тус ажиллаж байна. Үүнээс: гэр бүлийн гишүүн нь байнгын асаргаанд байдаг тул асарч сувилахаар 1, гэр бүлийн гишүүнээ эмчлүүлэхээр 4 албан хаагчийн ирүүлсэн хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, 4 албан хаагчид 22 хоногийн цалинтай чөлөө, 1 албан хаагчид 44 хоногийн цалингүй чөлөөг тус тус олгож шийдвэрлүүлсэн байна.

Албан хаагч өөрөө болон гэр бүлийн гишүүдийн эмчилгээний зардалд мөнгөн дэмжлэг хүссэн 3 өргөдлийг судалж шийдвэрлүүлэхээр СХОГ-т шилжүүлэв.

Гаалийн байгууллагын эцэг эхийн зөвлөлийн саналын дагуу албан хаагчдын хүүхдийг Найрамдал-11, Сансар -26, Шонхор-8 нийт 45 хүүхдийн санал хүлээн авч хүсэлтийг хүргүүлэв.

Казак түмний “Наурыз баяр”-ыг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган ажилласан 3 албан хаагчийг Гаалийн байгууллагын Жуух бичиг-ээр шагнав.

Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан албан хаагчдыг шагнаж урамшуулахаар нийт ГЕГ, дэргэдэх, харьяа 19 газар, хороо, ахмадын хороо буюу 34 нэгжээс 239 албан хаагчийн нэрс ирүүлсэн саналыг нэгтгэж Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 184 албан хаагчийн нэрс, холбогдох материалын хамт ГЕГ-ын даргын 2024.06.18-ны өдрийн 01/2466 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв. Үүнд:

Сангийн яамны жуух-45, Гаалийн албаны тэргүүний ажилтан-20, Хөдөлмөрийн хүндэт медаль-72, Алтангадас одон-26, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-21 тус тус байна.

Тайлант хугацаанд “Ахмадын байгууллага, ахмадуудтай хамтран ажиллах”, “Ахмадын сан” байгуулж ажиллах журам-ыг хэрэгжүүлэхээр Ахмадын хороо, СХОГ-аас

ирүүлсэн хүсэлтийн дагуу гаалийн байгууллагын ахмадын тоо бүртгэлийг /506 ахмад/ шинэчлэн гаргаж хүргүүлэв.

Ахмадын хорооноос уламжилсан буцалтгүй тусламж хүссэн 3 өргөдлийг “ахмадын сангаас” шийдвэрлүүлж, шагналд нэр дэвшүүлсэн 13 ахмадын нэрсийг гаалийн байгууллагын шагналын жагсаалтад нэгтгэж Сангийн яаманд хүргүүлж, байгууллагын ахмадын бүртгэлт хамрагдах 7 хүсэлтийг удирдлагад танилцуулж бүртгэлт авч, 1 хүсэлтэд хариуг өгч ажилласан байна.

Мөн 1 ахмад настны гэр бүл бөгөөд гаалийн байгууллагад /ЗҮГГ-ийн ТҮ-слесариар 26 жил ажиллаж байгаад элэгний хорт хавдар/ өвчний улмаас ажлаас чөлөөлөгдсөн тул мөнгөн дэмжлэг хүссэн өргөдөл ирүүлснийг өмнөх байгууллагад /албан хаагчдаа танилцуулахаар/ шилжүүлснийг тус газраас сайн үйлсийн хандиваар 3.9 сая төгрөг цуглуулж гэр бүлд нь хүлээлгэн өгчээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, Засгийн газраас орон даяар зохион байгуулж байгаа Эрүүл монгол хөтөлбөр төсөл “Эрт илрүүлэг үзлэг” -ийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан гаалийн байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сувилалд хамруулах асуудалд төсвийн хязгаарлалт хийсэн.

Гаалийн байгууллагын 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан хүрээнд 2023 онд нийт 1506 албан хаагчдыг “Эрт илрүүлэг” үзлэгт хамруулсан байдаг, үзлэгийн мөрөөр албан хаагчдын зонхилох төрлийн өвчлөлийн жагсаалтыг гаргаж түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж хэвшүүлэх, зөвлөмж хүргүүлэхээр 3-р улиралд төлөвлөж байна.

Гаалийн байгууллагад шинээр томилогдож байгаа 91 иргэнийг Төрийн тусгай албан хаагчийн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулж ажилд томилон шийдвэрлэж байна.

Дөрөв: ХУВИЙН ХЭРЭГ, ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ, АШИГЛАХ:

.Хувийн хэргийн үйл ажиллагааг дээшлүүлэхээр:

-Албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдлыг гаргаж, цаашид стандартын шаардлага хангасан өрөө, зориулалтын нягтаршуулсан шүүгээ хувийн хэргийн хавтас бусад хэрэгслийн тухай танилцуулгаар удирдлагад хүргэж, шаардлагатай хөрөнгийн тооцоолол гаргаж 2024 оны төсвийн төсөлд тусгуулж ажилласан.

-Энэ оны 03 дугаар сард харьяа газар, хороод / УХШИГГ, ЧХОНБГГ, УБГГ/ болон бусад төрийн байгууллагуудын /Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Гадаадын иргэний харьяатын газар/ хувийн хэргийн хадгалалт хамгаалалтын байдлыг газар дээр нь үзэн судалж, цаашид хийх ажил арга хэмжээний талаар санал танилцуулгыг удирдлагад хүргүүлсэн.

- Энэ оны 04 дүгээр сард Хувийн хэргийн ажлыг дээшлүүлэхээр “Хувийн хэрэг дээр ажиллах ажлын төлөвлөгөө” гарган ажиллаа. Төлөвлөгөөг Архивд бэлтгэх, Үндсэн ажлын хүрээнд гэсэн 2 чиглэлд хийсэн. Үүнд:

- Архивд шилжүүлэхээр 2019-2023 онуудыг хамарсан 320 албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарсан 67 албан хаагчийн 30 боть, нас барсан 20 ажилтны 8 боть, ажлаас чөлөөлөгдсөн 215 ажилтны 35 боть, халагдсан 18 ажилтны 6 боть нийт 79 боть хадгаламжийн нэгж баримтыг хүлээлгэн өгөв.

- Үндсэн ажлын хүрээнд ХНХ-ийн даргын 2024.04.12-ны өдрийн 01-1.1/1416 дугаартай албан бичгийг харьяа газар, хороодод хүргүүлж, албан хаагчдын 2021-2023 онуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний хуудас, сахилга ёс зүй, шагналын баримтын хуулбар бусад материалыг энэ оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлж харьяа 19 газар, хорооны нийт 1466 албан хаагчийн 15925 хуудас материалыг хувийн хэрэгт орууллаа.

- ГЕГ-ын нэгж, дэргэдэх байгууллагын 1348 албан хаагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээний хуудас, нийт албан хаагчийн мэргэшлийн түвшин тогтоох шалгалтын дүнгийн хуудас зэрэг 1189 хуудас материалыг хувийн хэрэгт орууллаа.

- Гаалийн байгууллагад шинээр ажилд орсон 91 албан хаагчийн хувийн хэрэг нээж, цахим анкетын мэдээлэл үүсгэж ажиллаж байна.

.Хүний нөөцийн мэдээллийн сан үүсгэх:

Захиргаа дотоод ажлын систем СЕРП-д нийт 1456 төрийн тусгай албан хаагчаас 1380 албан хаагчийн цахим анкетын баталгаажуулалт хийсэн.

Төрийн албаны зөвлөлийн ХНУМТС- санд гаалийн байгууллагын албан хаагчдын цалин, нэмэгдэл, шилжилт хөдөлгөөн болон бусад мэдээллийг орууллаа.

-Гаалийн ерөнхий газрын даргын “Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2024 оны 02 дугаар сарын А/123 дугаар тушаалын дагуу газар, хэлтэс, төвийн нэршил өөрчлөгдсөн болон шинээр байгуулагдсаны дагуу бүтцийн өөрчлөлтийг хийн ажлын байрыг нэмсэн.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Албан хаагчдад зэрэг дэв”Б/10 дугаар тушаалын дагуу 59 албан хаагчийн зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тушаалтай хавсарган оруулсан.

- Гаалийн ерөнхий газарт /Бүрдүүлэлтийн цахим төв г.м/ 2024 онд томилогдсон 60 албан хаагчийн үндсэн мэдээлэл болон үндсэн цалин, нэмэгдлийн /300 гаран нэмэгдэл/ мэдээллийг тушаалтай хавсарган оруулсан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 3 дугаар сарын 06-ны Б/139 дүгээр тушаалын дагуу Гаалийн төв лабораторийн 5 албан хаагчийн “Хүнд үйлдвэрийн салбарын мэргэшсэн инженерийн зэрэг”-ийн 15 хувийн нэмэгдлийг нэмсэн.

- Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 албан хаагчийг Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын дагуу ажилласан жилийг үндсэн мэдээлэлд тушаалтай хавсарган оруулж, тэтгэмж цэсэд төрийн албанд ажилласан жилийн мэдээллийг оруулсан.

- Өндөр насны тэтгэвэрт гарсан 3, чөлөөлөгдсөн 4 албан хаагчийн мэдээллийг оруулан цахим системээс чөлөөлсөн.

- Гаалийн байгууллагад ажилд томилогдсон 59, сэлгэн ажиллуулсан 171 албан хаагчийн мэдээллийг Сэрп-Хүний нөөцийн Туршлага санд мэдээлэл үүсгэлээ.

Мэдээллийн сан ашиглах чиглэлээр:

Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ ажилтны мэдээллийн дата үүсгэж, ажилд томилж, чөлөөлөх, шагнаж урамшуулах, тусламж, тэтгэмж, ажилласан жил, сахилга хариуцлага ёс зүйн хариуцлага тооцох, сургах мэргэшүүлэх бүх төрлийн судалгаа, мэдээллийг үйл ажиллагаанд эх сурвалж болгон ашиглаж байна.

Тав: ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДАЛ ХАНГАХ:

Гаалийн байгууллагын албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан Жендэрийн талаарх мэдээлэл болон Ажлын байрны бэлгийн дарамт, жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхахтай холбоотой гомдлыг хүлээн авах талаарх мэдээллийг CERP системд байршууллаа.

Жендэрийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад хэрэгжүүлэх жендэрийн стратегийн үнэлгээ”-ний талаар техникийн зөвшилцөх сургалтад 15 албан хаагчтай хамт оролцлоо. Уг сургалтын хүрээнд Гаалийн байгууллагад Жендэрийн үндэсний хорооноос “Жендэрийн стратегийн үнэлгээ”-г хийхээр боллоо. Тус үнэлгээний хүрээнд Улаанбаатар хот дахь гаалийн газрын 10 албан хаагчтай Жендэрийн үндэсний хорооны зөвлөх ажилтан фокус ярилцлага хийлээ.

Харьяа гаалийн газар, хороодод Жендэрийн асуудлыг хариуцах албан хаагчдын судалгааг гаргалаа. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах гаалийн байгууллагын дэд салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн батлуулж, Татварын ерөнхий газрын Жендэр хариуцсан ажилтантай уулзаж, туршлага судаллаа.

Зургаа: ӨРГӨДӨЛ,ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР:

Хүний нөөцийн хэлтэст хуваарилагдсан ирсэн бичиг 596, явсан бичиг 269, өргөдөл хүсэлт 273 /шийдвэрлэсэн 244, шилжүүлсэн 32, судалж байгаа 29, хугацаа хэтэрч хариу өгсөн 11, хугацаа дөхсөн 3/ хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж байна.

Долоо. АЖЛЫН ЦАГ АШИГЛАЛТ, АЛБАН ТОМИЛОЛТЫГ БҮРТГЭХ, ХЯНАХ

Цаг ашиглалтыг гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтын дагуу мөрдөж ажиллаж байна. Ажлын цагийг нүүр таних төхөөрөмжөөр бүртгэл

үүсгэсэн. Ажилтан аливаа чөлөө авах тохиолдолд нэгжийн удирдлагад бичгээр хүсэлт гарган мэдэгдэж, зөвшөөрөл авч ажилласан. Эхний хагас жилийн байдлаар тасалсан, хоцорсон ямар нэгэн зөрчилгүй байна.

Найм .СУРГАЛТ,СУДАЛГАА, ЛАВЛАГАА

1.Хүний нөөцийн чиглэлээр ажлын мэргэшил чадвараа дээшлүүлэхээр ГУБ Б.Мөнхтуул Б.Батчимэг нар Удирдлагын академиас энэ оны 05 дугаар сарын 27-30-ны хооронд зохион байгуулсан “Төрийн албан хаагчдыг чадавхжуулах нь: Хүний нөөцийн удирдлага” сэдэвт 40 цагийн цахим, танхим хосолсон сургалтад хамрагдсан.

- HR consulting firm байгууллагаас зохион байгуулдаг хүний нөөцийн чиглэлийн 4 удаагийн цахим сургалтад хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн 11 удаагийн цахим сургалтад Хүний нөөцийн хэлтсийн ажилтнууд хамрагдсан.

БНСУ-д зохион байгуулагдсан Хүний нөөцийн удирдлагын сургалтад ГУБ Б.Батчимэг хамрагдсан байна.

Хүний нөөцийн үйл ажиллагаанд хийгдсэн 12 төрлийн судалгаа хийгдсэн.Үүнд

1.Гаалийн байгууллагын албан хаагчдын нас, хүйс, боловсрол, албан тушаалын ангилал, гаалийн байгууллагад ажилласан жилийн судалгаа

2.Бичиг баримтын бүрдүүлэлтийн чиглэлээр батлагдсан орон тоо болон ажиллаж байгаа албан хаагчдын судалгаа

3.Гаалийн байгууллагын албан хаагчдын байр, орон сууц болон зээлийн судалгаа /1806 албан хаагч судалгаанд хамрагдсан/

4.Тусгай шалгалтаар томилогдсон 272 албан хаагчийг гаалийн ерөнхий газар болон газар, хороодоор нь ялган судалгааг гаргасан. /7 сард-155, 10 сард-64, 1 сард-53 албан хаагч/

6.Гаалийн ерөнхий газрын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны судалгаа

7.Гаалийн байгууллагын орон тооны 1-р улирлын мэдээг /2024.01.05-ны байдлаар/ шинэчилсэн хүснэгтийн дагуу бөглөн Статистик, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлсэн.

9.Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газарт ажиллаж байгаа хятад хэлтэй албан хаагчдын судалгаа. /35/

10.Санхүү, хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн дотоод зурвасын дагуу цахилгааны инженер мэргэжилтэй 8 албан хаагчийн судалгааг гарган хүргүүлсэн.

11.Харьяа гаалийн газар, хороонд Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч болон Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдын судалгаа

12.Гаалийн байгууллагын төрийн тусгай 1440 албан хаагчийн ажилласан жилийг нотлох баримттай тулган Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчдын судалгааг гаргасан. Энэ хүрээнд УБГГ-2, Гашуунсухайт дахь гаалийн газарт 1, Замын-Үүд дэх гаалийн газарт 1, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газарт 1, нийт 5 удаагийн зөвлөмж, чиглэл хүргүүлж ажилласан байна.

ЛАВЛАГАА:

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 9 удаагийн албан бичгийн хүсэлтийн дагуу 13 ажилтны 196 хуудас хувийн хэргийн материалыг хуулбарлан нотлох баримтын шаардлага хангаж хүргүүлсэн байна.

Ес. ЦАГ ҮЕИЙН ШИНЖТЭЙ БУСАД АЖЛЫН ТАЛААР

2024.01.15-ны өдрийн 01/183 дугаартай Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу 2018-2023 оны хооронд ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа газар, хэлтэс, төвийн дарга /давхардсан тоогоор 53/ нарын мэдээлэл болон анкет, тушаалын хуулбарыг нотлох баримтын шаардлага хангуулан 418 хуудас баримтыг хүргүүлсэн.

УИХ-ын дэргэдэх хяналтын түр хорооноос ирүүлсэн албан бичгийн хүсэлтийн дагуу Эм био бэлдмэлийн хяналт хариуцсан 17 албан хаагчийн анкет, ажилд томилогдсон чөлөөлөгдсөн тушаал, албан тушаалын тодорхойлолтын хуулбар бүхий 138 хуудас материалыг хүргүүлэв.

Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажлын чиглэлээр:

Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой ажлаар ГЕГ-ын нэгжүүдтэй 176 дотоод зурвасаар, харьяа газар, хороотой 270 гаруй албан бичгээр хамтран ажилласан байна.

-Хүний нөөцийн үйл ажиллагааны явцад бий болсон 2018-2022 онуудын баримт бичгүүд, 2023 оны тус нэгжийн хөтлөх нэрсийн жагсаалтын дагуу баримт бичгийг төрөлжүүлэн архивын нэгж үүсгэж, байгууллагын архивд шилжүүлэн өгөв. Үүнд:

2018 оны Ирсэн бичиг-1 боть , 2021 оны ирсэн бичиг-1 боть, 2022 он баримтын 7 боть хадгаламжийн нэгж, 2023 оны баримт бичгийн 33 боть хадгаламжийн нэгж үүсгэсэн. Үүнд: ГЕГ-ын даргын Б тушаал-6 боть, А тушаал-6 боть, ирсэн бичиг- 3 боть, ирсэн дотоод зурвас -4 боть, явсан дотоод зурвас -2 боть, өргөдөл хүсэлт-3 боть, албан хаагчийн Шагналын материал-1 боть, Нээлттэй хэлэлцүүлгийн материал-1 боть, ЗХЭГ-ын “Шүүр” ажиллагааны хүрээнд хийгдсэн материал-3 боть, ТАЗ-ийн ГЕГ-ын Салбар зөвлөлийн тусгай шалгалтын 4 боть байна.

Арван . ДҮГНЭЛТ, САНАЛ

Тус нэгж нь тайлант онд Хэлтсийн дарга-1, ГУАБ-1, ГУБ-4 /1 дутуу/ орон тоогоор ажиллаа. Өмнөх онтой харьцуулахад үүссэн асуудлуудыг зохих түвшинд шийдвэрлэсэн тул ажлын ачаалал жигдэрч хэвийн ажилласан.

Гаалийн тухай хуулийн 280.7 дэх хэсэгт “Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох” болсон нь албан хаагчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлсэн ач холбогдолтой томоохон шийдвэр байлаа.

Салбар зөвлөлөөс 2023-2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6 удаагийн тусгай шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулж, сул орон тоог нөхөх ажил дэс дараатай амжилттай явуулж байна.
